БАТЛАВ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМЫН ЗАСАГ ДАРГА М.ЦЭВЭЭНРАВДАН

2026 оны 03 дугаар сарын 03.

ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ, САЙЖРУУЛАХ, ТӨЛӨВШҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

Тавигдах ерөнхий шаардлага

Тоног төхөөрөмж нь технологийн хувьд орчин үеийн, дэвшилтэт технологи байх бөгөөд ашиглахад энгийн, ажиллагааг хянах боломжтой, Олон Улсын бүтээгдэхүүний чанарын CE, FDA, ISO, TUV зэрэг стандартуудын аль нэгийг хангасан байх

- Тухайн тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний сургалтыг холбогдох эмч, инженер, мэргэжилтнүүдэд зохион байгуулах
- Эмнэлгийн инженер болон ханган нийлүүлэх байгууллагын инженерийн ажил үүргийн жагсаалтыг ирүүлэх
- Бүрэн ажиллагааг хангахын тулд бараанд зайлшгүй шаардлагатай бүх нэмэлт ба дагалдах хэрэгслүүдийг хамтад нь санал болгох
- Баталгаат хугацаа 2 жилээс багагүй байх ба баталгаат хугацааны засвар үйлчилгээг ханган нийлүүлэгч байгууллага хариуцаж, баталгаат засварын гэрээг хүлээн авагч байгууллагатай тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгөх үед байгуулах.
- Баталгаат хугацаа дууссаны дараа сэлбэг материалаар хангах боломжтой байх үнийн саналыг тоног төхөөрөмж тус бүр дээр дагалдуулсан байх
- Ашиглалтын болон засвар үйлчилгээний дараах гарын авлагыг англи, монгол хэл дээр тухайн аппарат, тоног төхөөрөмжийг дагалдуулж өгөх
  - хэрэглэгчийн гарын авлага
  - засвар үйлчилгээний гарын авлага
  - баталгаат хугацаанд хийх техник үйлчилгээний график /өдөр тутам, 7 хоног, сарын, шалгах хуудас/

<u>Гэрээ байгуулагдсаны дараа:</u>

- “Техникийн комиссын урьдчилсан дүгнэлт” гаргуулах
- Цацрагийн эх үүсвэр бүхий тоног төхөөрөмжийн хяналтыг холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж баталгаажуулсан байх.

LUMITESTER SMART

Lumitester Smart нь 30 секундийн дотор ATP+ADP+AMP илрүүлэх замаар эрүүл ахуйг хянах зориулалттай өндөр мэдрэмжтэй, зөөврийн люминометр юм.

Энэ нь гадаргуу болон шингэн дэх цэвэрлэгээний үр ашгийг хэмждэг Bluetooth-ээр холбогддог. Төхөөрөмж нь газар дээрх ариун цэврийн байдлыг хурдан шалгахад тохиромжтой.

№	Тоног төхөөрөмжийн нэрс	Тоо ширхэг	Гол онцлог ба үзүүлэлт
1	Lumitester Smart	1	А3 технологи: Стандарт ATP шинжилгээтэй харьцуулахад хүнсний үлдэгдэл болон бичил биетнийг илрүүлэхэд илүү өндөр мэдрэмжтэй байхын тулд ATP, ADP, AMP-ийг илрүүлдэг. Хурдан үр дүн: Ойролцоогоор 10-30 секундийн дотор тоон өгөгдлийг өгдөг. Холболт: Өгөгдөл хадгалах, шинжлэх зорилгоор ухаалаг утас, таблет, компьютертой Bluetooth-ээр холбогддог. Хэрэглээ: хоол хүнс үйлдвэрлэх гал тогоо, эрүүл мэндийн үйлчилгээнд тохиромжтой. Дэлгэцийн төрөл: Органик-LED-Дэлгэц Порт: USB, Bluetooth Температурын хүрээ: 5 - 40 °C Хэмжлийн нэгж: RLU Өгөгдлийн санах ой: 2000 шинжилгээ Цахилгаан хангамж: 2 (AA) батарей Жин: 255 гр Урт х Өргөн х Өндөр: 176 х 65 х 176 мм Дээж бэлтгэх Дээж бэлтгэхгүйгээр Инкубацийн хугацаа 10 сек 12 сарын баталгаат хугацаа.
2	Ариутгалын системтэй робот	1	Ариутгалын системтэй робот нь том талбайг хурдан ба сайтар ариутгах чадалтай ба хүний эрүүл мэндэд хор уршиггүй байна. Гар утсанд роботын аппликейшнаар холбож тохируулж болох аргуудтай, шүршигч олон төрлийн хошуутай ариутгалын робот байна.
			Бүтээгдэхүүний үзүүлэлт -Ариутгалын бүх төрлийн бодисыг ашиглаж болох -Алсын ухаалаг удирдлагатай -Атомжуулсан бөөмийн хэмжээ 2~5um -Батарейны багтаамж 20800mAh/37V -Батарейны ашиглалтын хугацаа 3~4 цаг -Цэнэглэх хугацаа 3-5 цаг -Ажиллах цаг 4-5 цаг

			-Ариутгалын манангийн хэмжээ (1200/2000/3000 мл/цаг) -Усны савны эзлэхүүн 10л -Ариутгалын арга- Нэг удаагийн ариутгал болон давтан ариутгал -Зөөхөд хөнгөн, овор хэмжээ багатай байх
3	Кварцын гэрэл	8	-180 градус өнцгөөр чөлөөтэй тохируулга хийх боломжтой. -360 градус 60-200м2 талбайг халдваргүйжүүлэх чадалтай байх -Нэг удаа ариутгал хийх хугацаа 0-60 минут -60 вт хэт ягаан туяагаар ариутгах хүчин чадалтай. -Нийт чадал 120 вт -Цахилгаан хангамж 220в -Хөдөлгөөн саадгүй дугуйтай байх -Ямар ч төрлийн өрөөний гадаргуу болон агаарыг халдваргүйжүүлэхэд боломжтой -гэрэл нь эвхэгддэг -лампын тоо 2 ширхэг /запаас ламп 2-4 ширхэг/ байх -Алсын зайны удирдлагатай, -Асааснаас хойш 15 сек дараа ажиллаж эхлэх горимтой байх -Төмөр гадаргуутай

БОЛОВСРУУЛСАН: ХАНБОГД СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ХАЛДВАР ХЯНАЛТЫН БАГИЙН ДАРГА Б.ӨЛЗИЙСАЙХАН